



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 52

Өлгий

2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "з", Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд 2019 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг нэгдүгээр,

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг хоёрдугаар хавсралтын "а", иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад аялал жуулчлалын зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг "б", иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан шинээр эзэмшүүлэх газрын байршил хэмжээг "в", төсөвт байгууллагад эзэмшүүлэх газрын байршил хэмжээг "г", шинээр сууршлын бүс бий болгох газрын төлөвлөлт "д",

Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр үнэгүй өмчлүүлэх газрын байршил хэмжээг гуравдугаар хавсралтын "а", иргэдэд одоо эзэмшиж буй хашааны газрыг үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг "б", иргэнд аж ахуйн зориулалтаар үнээр нь өмчлүүлэх газрын байршил, хэмжээг "в", иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд болон ААН, байгууллагад зориулан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, тариалангийн зориулалтаар шинээр эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг "г",

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын байгууллага, хуулийн этгээдэд ашиглуулах газрын байршил, хэмжээг дөрөвдүгээр,

Суурьшлын бүсэд шинээр барих үерийн хамгаалалт, зам шугам, сүлжээний доорх газрын төлөвлөлтийг тавдугаар, Нийтийн зориулалттай эдэлбэр газрын төлөвлөлтийг зургаадугаар, Иргэнд ашиглуулах газрын байршил хэмжээг долоодугаар, Ашигт малтмалын олборлох зориулалтаар эзэмшүүлэх газрын төлөвлөлтийг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

000129

Хоёр. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад эзэмшүүлэх, ашиглуулах газрын зориулалт, байршил, хэмжээг баталсан хуваарийн дагуу хэрэгжүүлэх, ажлыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /А.Гылымхан/-д даалгасугай.

Гурав. Сумынхаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлахдаа цаашид аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг уялдуулан сумын ИТХ-аар батлуулах, орон нутгийн тусгай хамгаалтад авах газруудыг эрчимжүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАУЫРЖАН